



**НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 1/21

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11, Дотоод хяналтын зохион байгуулах журмын 2.2, 3.4, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны хэг/595 тоот албан бичиг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 03/1564 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь: -

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, авлигатай тэмцэх “шүгэл, шүүр, шувуу, шилжүүлэн авах, шил” ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу “Шүүр” ажиллагааг хэрэгжүүлэн Төрийн албаны хууль, тогтоомж, холбогдох шаардлагыг зөрчин томилогдсон албан хаагчдыг олж тогтоон дотоод хяналт хийж, үнэлэлт дүгнэлт гаргах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хасралтаар баталсугай.

2. Дотоод хяналтыг шуурхай зохион байгуулж, дүгнэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн дотор удирдлагад танилцуулахыг Ажлын хэсгийн дарга (Б.Батбилэг)-д, биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тогтоосон хугацаанд хүргүүлэн ажиллахыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (О.Батбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (С.Цэдэнсодном)-т даалгасугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
даргын 2023 оны 03 дугаар сарын 23-ны  
өдрийн 2/21 дүгээр тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

Б.БАТБИЛЭГ

(Хууль, дотоод хяналтын  
хэлтсийн дарга)

ГИШҮҮД:

Н.НАРАНГЭРЭЛ

(Хууль, дотоод хяналтын  
хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Л.БОЛОРЧУЛУУН

(Хууль, дотоод хяналтын  
хэлтсийн Хуулийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн)

Х.НОМИН

(Хууль, дотоод хяналтын  
хэлтсийн Хуулийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн)

Д.ОЮУНТУУЛ

(Хууль, дотоод хяналтын  
хэлтсийн Дотоод хяналтын  
инженер)

Э.ГООМАРАЛ

(Хууль, дотоод хяналтын  
хэлтсийн Дотоод хяналтын  
инженер)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

О.БАТБААТАР

(Хууль, дотоод хяналтын  
хэлтсийн Дотоод хяналтын  
мэргэжилтэн)